

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ
ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код:НТАГ-2026/189/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Audit.mn Нийслэл дэх Төрийн аудитын газар 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Платиниум прогресс аудит ХХК-ийн захирал: Ж.Баяртуул Утас:99066015, Цахим хаяг: Auditbalance6015@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 594

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ О.БУЯНГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газар нь 2025 оны ажилчдын бүтэц орон тоог 410 байхаар баталсан боловч 322 орон тоогоор ажилласан байна.

Тайлант оны нийт орлогыг 23,166.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 23,058.4 сая төгрөгөөр, 107.7 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 24,830.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 24,647.0 сая төгрөгийн зардал гарган 183.7 сая алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

© Улаанбаатар /Орлого/Баталсан 2026 1426050565

Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгууллагын бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн баталсан боловч тогтоосон хэмжээнээс нийт 238.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 92.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,148,290,873.14	2,571,769.09
1.1.2	Дансны авлага	467,250,396.13	1,104,384,306.07
1.1.6	Бараа материал	298,404,030.09	541,444,264.91
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	36,143,945.20	33,413,240.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,950,089,244.56	1,681,813,580.07
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,598,741,947.39	14,324,462,434.98
1.2.2	Биет бус хөрөнгө	163,459,650.03	60,093,138.92
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,762,201,597.42	14,384,555,573.90
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,712,290,841.98	16,066,369,153.97
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	56,327,111.23	137,109,304.15
2.1.1.2	Цалингийн өглөг	488,872,876.93	13,031,003.98
2.1.1.3	Татварын өглөг	111,116,068.90	102,109,235.24
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,131,253.49	239,917,006.18
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	4,166,992,842.26	7,103,318,164.55
2.1.1.9	Нөөц / өр төлбөр/		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,824,440,152.81	7,595,484,714.10
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	114,458,117.64	6,524,795,057.36
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	114,458,117.64	6,524,795,057.36
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,938,898,270.45	14,120,279,771.46
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : а) төрийн	595,447,360.00	595,447,360.00
2.3.2	б) хувийн		
2.3.3	б) хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	53,058,518.70	53,058,518.70
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	209,000,000.00	209,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	915,886,692.83	1,088,583,503.81
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,773,392,571.53	1,946,089,382.51
2.4	ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,712,290,841.98	16,066,369,153.97

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон. /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого /цэвэр/	19,430,556,186.97	24,830,732,335.97
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	
3	Нийт ашиг (алдагдал)	19,430,556,186.97	24,830,732,335.97
4	Түрээсийн орлого		
5	Ерөнхий ба удирдлагын зардал	18,466,635,543.42	24,471,846,912.85
6	Санхүүгийн зардал	7,903,705.63	16,172,773.39
7	Бусад зардал		3,362,662.45
8	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз		155,610,104.16
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	956,016,937.92	183,739,883.12
11	Орлогын татварын зардал	95,333,595.84	18,373,988.31
12	Татварын дараах ашиг (алдагдал)	860,683,342.08	165,365,894.81
13	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	860,683,342.08	165,365,894.81
15	Бусад дэлгэрэнгүй орлого		
16	Орлогын нийт дүн		
17	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон. /төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	595,447,360.0	53,058,518.7	209,000,000.0	915,886,692.8	1,773,392,571.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				7,330,916.1	7,330,916.1
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				165,365,894.8	165,365,894.8
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	595,447,360.0	53,058,518.7	209,000,000.0	1,088,583,503.8	1,946,089,382.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,716,540,442.92	22,606,089,937.20
	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	18,669,051,732.92	22,516,068,645.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	34,273,437.00	55,712,680.00
	Бусад мөнгөн орлого	13,215,273.00	34,308,612.20
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,516,093,320.70	22,965,668,495.25
	Ажиллагчдад төлсөн	8,026,528,744.00	10,973,485,325.34
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,476,425,337.69	2,881,414,890.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	789,760,860.02	1,773,777,603.00
	Ашиглалтын зардалд төлсөн	295,505,253.17	262,050,093.14
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,692,666,849.00	3,290,515,399.02
	Хүүний төлбөрт төлсөн	1,389,005.63	12,448,932.95
	Татварын байгууллагад төлсөн	955,267,522.27	1,133,481,235.14
	Даатгалын төлбөрт төлсөн	11,065,995.00	23,226,709.00
	Бусад мөнгөн зарлага	2,267,483,753.92	2,615,268,307.66
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,200,447,122.22	(359,578,558.05)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	52,279,430.00	786,140,546.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	52,279,430.00	786,140,546.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(52,279,430.00)	(786,140,546.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,819,023,861.00	6,251,709,952.63
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,819,023,861.00	6,251,709,952.63
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,819,023,861.00	6,251,709,952.63
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,819,023,861.00	6,251,709,952.63
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,148,167,692.22	(1,145,719,104.05)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,148,290,873.14	1,148,290,873.14
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,492,904.92	2,571,769.09

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон.

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр	2024 оны гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү + хэмнэсэн, - хэтэрсэн	Биелэлт хувь
	Нийт орлого	19,430,556,186.97	23,166,160,554.00	24,830,732,335.97	(1,664,571,781.97)	107.1
1	Төвлөрүүлэх орлого	10,146,205,413.12	8,895,014,796.00	8,274,494,917.94	620,519,878.06	93.0
2	Зам талбайн санхүүжилт	8,954,048,606.55	11,229,232,560.00	11,525,167,265.00	(295,934,705.00)	102.6
3	ААНБ-н орлого	-	1,691,482,260.00	1,172,613,488.00	518,868,772.00	69.3

Сонгинохайрхан дүүргийн тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

4	Ногоон байгууламж	330,302,167.30	371,094,000.00	304,642,251.00	66,451,749.00	82.0
5	Дүүргийн захирамжтай ажил / хур хог зайлуулах		979,336,938.00	1,791,008,020.00	(811,671,082.00)	182.8
6	Иргэдийн бүлэг цэвэрлэгээний ажил			89,746,195.00	(89,746,195.00)	-
7	Бусад орлого			1,011,398,199.03	(1,011,398,199.03)	-
8	Үнэ төлбөргүй орлого			661,662,000.00	(661,662,000.00)	-
Нийт зардал		18,474,241,362.42	23,058,399,811.15	24,646,992,452.85	(1,588,592,641.70)	106.8
1	Үндсэн цалин	10,069,524,242.79	13,108,888,470.00	12,555,973,576.77	552,914,893.23	95.7
2	НДШ-ийн зардал	1,352,369,549.83	1,900,788,828.15	1,691,036,180.82	209,752,647.33	88.9
3	Сэлбэг материал	1,046,777,345.00	1,250,000,000.00	1,414,345,451.80	(164,345,451.80)	113.1
4	Шатахууны зардал	1,725,262,095.89	1,781,115,847.00	1,558,977,246.12	222,138,600.88	87.5
5	Түрээсийн зардал	231,996,000.00	234,000,000.00	223,057,760.00	10,942,240.00	95.3
6	Шуудан холбоо интернэт	5,406,492.00	6,636,000.00	2,993,927.30	3,642,072.70	45.1
7	Дохиоллын зардал	9,112,339.00	34,732,000.00	71,236,976.19	(36,504,976.19)	205.1
8	Авто машины татвар даатгал	20,281,641.00	74,402,260.00	62,142,092.60	12,260,167.40	83.5
9	Тэтгэмж, тусламж	82,154,618.00	115,000,000.00	169,768,348.00	(54,768,348.00)	147.6
10	Аж ахуйн, хангамжийн зардал	549,756,756.36	812,486,000.00	583,699,918.26	228,786,081.74	71.8
11	Давс бодис	1,377,000.00	495,000,000.00	1,077,290,000.00	(582,290,000.00)	217.6
12	Дотоод хэрэгцээний зардал	16,170,230.00	7,552,000.00	6,117,401.00	1,434,599.00	81.0
13	Бичиг хэргийн зардал	168,443,503.33	19,424,000.00	20,978,245.00	(1,554,245.00)	108.0
14	Хөдөлмөр хамгааллын зардал	11,986,263.17	211,633,000.00	562,493,306.32	(350,860,306.32)	265.7
15	Гэрэл цахилгааны зардал	301,910,461.05	21,600,000.00	7,257,873.65	14,342,126.35	33.6
16	Орлогын шимтгэлийн зардал	174,983,231.50	310,000,000.00	326,763,041.40	(16,763,041.40)	105.4
17	Засвар үйлчилгээний зардал	1,500,000.00	175,000,000.00	199,808,845.64	(24,808,845.64)	114.1
18	Сургалтын зардал	502,119,335.45	14,275,000.00	14,820,000.00	(545,000.00)	103.8
19	Элэгдлийн зардал	1,897,426,853.00	502,028,668.00	1,316,121,753.37	(814,093,085.37)	262.1
20	Тохижилт ногоон байгууламжийн зардал	305,683,405.05	1,683,837,738.00	2,427,168,073.00	(743,330,335.00)	144.1
21	Бусад зардал		300,000,000.00	354,942,435.61	(54,942,435.61)	118.3
Нийт ашиг /алдагдал/		956,314,824.55	107,760,742.85	183,739,883.12	(75,979,140.27)	
Татвар		95,631,482.45		18,373,988.31		

Татварын дараах ашиг/алдагдал	860,683,342.09		165,365,894.81		
-------------------------------	----------------	--	----------------	--	--

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 78,894.6 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитын өгсөн албан шаардлагын биелэлтийг хангаж, СХД-ийн 37 дугаар хороонд байршилтай, 104,518.4 мянган төгрөгийн үнэлгээ бүхий 14,988 м.кв газрыг СХД-ийн газар зохион байгуулалтын газрын даргын тушаалаар шилжүүлсэн байна. Тухайн байгууллагын эзэмших эрх бүхий 9992 м.кв газрын үнэлгээ нь газрын нэгдсэн сангийн удирдлагын цахим тодорхойлолтоор 97,202.1 мянган төгрөг бөгөөд санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгөөр 38,302.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Мөнгөн хөрөнгийн тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний зардлыг 40,592.42 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, MNS-6817-4:2020 стандартын санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг; 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” заалт, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 243,481.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 238,660.4 төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4,820.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 243,481.2 мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгууллагын бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн баталсан боловч цалинг олгохдоо тогтоосон хэмжээнээс нийт 238,660.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8-д “цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулал”, 20 дугаар зүйлийн 20.4-т “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох” нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар тогтоолын “Байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад заасантай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-өөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлээгүй, цалинг нэмэгдүүлэн олгосон зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 4,820.8 мянган төгрөгийг бараа материал болон бичиг хэргийн зардалд зарцуулсан байна. Энэ нь МУЕС-ын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.1-т “Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулж төсвийг хуваарилан

зарцуулахдаа үр ашиггүй, тэвчиж болох зардлыг танах, хэмнэлтийн горимыг чанд мөрдөн ажиллах талаар харьяа байгууллагын удирдлагад үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож ажиллах", 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох", 1.4.3-т "тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, хөтөлбөр арга хэмжээний зардлуудыг хэмнэх, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өөрийн эзэмшлийн газрын үнэлгээг газрын үнэлгээнээс бага үнээр үнэлж тайланд тусгасан байна.	1	38,302.1			1	38,302.1	1	38,302.1				
Мөнгөн хөрөнгийн тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний зардлыг дутуу тайлагнасан байна.	1	40,592.4			1	40,592.4	1	40,592.4				
Дүн	2	78,894.5			2	78,894.5	2	78,894.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2,312,741.8 мянган төгрөгийн 12 худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй байна.	1	2,312,741.8					1	2,312,741.8
Нийт дүн	1	2,312,741.8					1	2,312,741.8

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бараа материал, бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.	1	4,820.8					1	4,820.8				
ТУЗ-ийн тогтоосон хэмжээнээс цалинг нэмэгдүүлэн олгосон байна	1	238,660.4			1	238,660.4						
Дүн	2	243,481.2			1	238,660.4	1	4,820.8				